*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# ЧАНАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА И.ХАЙРАТБЕКИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр:Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
Нэгжийн нэр: Чанар хяналтын газар

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 1: ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, ХӨРӨНГӨ, НӨӨЦИЙГ ХУВААРИЛАН ЗОХИЦУУЛАХ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГ ЭРХЛЭХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | |
| **Зорилт 1.1. Холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах арга хэмжээний биелэлт** | | | |
| 1.1.1 | Салбарын хууль тогтоомж, журам, дүрэм, стандарт, байгууллагын дотоод журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах | 100 | 70 |
| 1.1.2 | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангах | 100 | 70 |
| 1.1.3 | Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 100 | 70 |
| 1.1.4 | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх | 100 | 70 |
| **Зорилт 1.2. Хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх** | | | |
| 1.2.1 | Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаараар болон бусад хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх, хяналт тавих | 100 | 70 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ, ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ, НЭГТГЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ ОНОВЧЛОХ, ЦАХИМЖУУЛАХ, СУДАЛГАА ХИЙХ, АЛБАН ХААГЧИЙГ САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ** | | | |
| **Зорилт 2.1. Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой системийг нэвтрүүлэх, зохицуулалт хийх, нэгтгэх, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, үйлчилгээг оновчлох, цахимжуулах, судалгаа хийх** | | | |
| 2.1.1 | Төрийн цахим үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хүргэж байгаа эсэхэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | 100 | 70 |
| 2.1.2 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (киоск)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах | 100 | 70 |
| 2.1.3 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск), цахим лавлагааны систем, албан бичиг солилцооны систем, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгох систем, нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний систем, и-Монгол, и-бизнес платформ, нийтийн өргөдөл гомдлын систем, төлбөрийн систем, huduu.gov.mn гэх мэт системийн хөгжүүлэлт, сайжруулалтын талаар санал боловсруулах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.4 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д дэд админ, операторын админ, операторын эрх нээх, цуцлах, хяналт тавих | 100 | 70 |
| 2.1.5 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д нэвтрүүлэх үйлчилгээг эрэмбэлэх, санал боловсруулах, үе шаттайгаар нэмэгдүүлэх | 100 | 70 |
| 2.1.6 | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгт хяналтын систем нэвтрүүлэх | 100 | 70 |
| **Зорилт 2.2. Албан хаагчийг салбарын чиглэлээр сургах, мэргэшүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системийн талаарх сургалт зохион байгуулах, үр дүнг тайлагнах** | | | |
| 2.2.1 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | 100 | 70 |
| 2.2.2 | Албан хаагчийг салбарын чиглэлээр сургах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах | 100 | 70 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 3: УЛСЫН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХҮРГЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ОРОН НУТАГТ САЛБАРЫН БОДЛОГЫН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ** | | | |
| **Зорилт 3.1. Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг байгуулах, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах, орон нутагт салбарын бодлогын холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх** | | | |
| 3.1.1 | Төрийн цахим үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох судалгаа хийх | 100 | 70 |
| 3.1.2 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2024 онд хамтрах ажиллах гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | 100 | 70 |
| 3.1.3 | Орон нутагт харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим засаглал, нийтийн мэдээллийн дэд бүтэц, кибер аюулгүй байдал, цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах, салбарын хүний нөөцийн хөгжил, салбарын мэргэжлийн хяналтын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | 100 | 70 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 4: ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН ХҮРГЭЖ БАЙГАА ЭСЭХЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | |
| **Зорилго 4.1. Холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих** | | | |
| 4.1.1 | Үйлчилгээний ажилтны үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох байгууллагад тайлан хүргүүлэх | 100 | 70 |
| 4.1.2 | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж хүргүүлэх | 100 | 70 |
| **Зорилт 4.2.Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг шинжлэх** | | | |
| 4.2.1 | Үйлчилгээний цэгийн байршлын хүртээмжийг сайжруулах талаар судалгаа хийх, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх | 100 | 70 |
| 4.2.2 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ээр төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашгийн шинжилгээ хийх | 100 | 70 |
| **Зорилт 4.3. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ийн үйл ажиллагаанд хяналт тавих** | | | |
| 4.3.1 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ийн алдаа, доголдлыг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагад мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| 4.3.1 | Үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх ур чадварт хяналт тавих | 100 | 70 |
| **Зорилт 4.4.Үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх ур чадварт хяналт тавих** | | | |
| 4.4.1 | Ажлын байранд тавигдах шаардлага, үйлчилгээний ажилтны хандлага, харилцаа, үйлчилгээ үзүүлэх ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж батлах | 100 | 70 |
| 4.4.2 | Мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдтэй хамтран ажиллаж, зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 4.4.3 | Олон улсын стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| **Зорилт 4.5.Төрийн үйлчилгээний процессыг оновчлох, дахин загварчлах, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, хяналт тавих** | | | |
| 4.5.1 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлтийн оруулах санал боловсруулах, хүргүүлэх | 100 | 70 |
| 4.5.2 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр мэдээлэл хариуцагч байгууллагатай хамтран ажиллах | 100 | 70 |
| 4.5.3 | Төрийн үйлчилгээний процессыг оновчлох, дахин загварчлах, цахимжуулах ажлын хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах | 100 | 70 |
| 4.5.4 | Үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх санал боловсруулах | 100 | 70 |
| 4.5.5 | Төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системд мэдээлэл байршуулах, хяналт тавих /huduu.gov.mn, shilen.gov.mn/ | 100 | 70 |
| **Зорилт 4.6 Үйл ажиллагааг зохион байгуулах, өөрийн газрын хариуцсан чиг үүргийн хүрээнд удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд гүйцэтгэх** | | | |
| 4.6.1 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | 100 | 70 |
| 4.6.2 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах | 100 | 70 |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | |
| 1. | Хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулах | 100 | 70 |
| 2. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2024 онд хамтрах ажиллах гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх удирдамж боловсруулж, батлуулах | 100 | 70 |
| 3. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэж байгаа хилийн чанад дахь “ХУРДАН” цэгийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн хяналт, шалгалтын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулах | 100 | 70 |
| 4. | Газрын ажилтнуудаас нийт албан хаагчдад сургалт хийх төлөвлөгөөг нэгтгэн Захиргаа удирдлагын газарт хүргүүлэх | 100 | 70 |
| 5. | Байгууллагад мөрдөгдөж байгаа стандартуудын тайланг авч нэгтгэн Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлэх | 100 | 70 |
| 6. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам, ажлын байранд тавигдах шаардлага, үнэлгээний хуудас, үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | чадвар, харагдах байдал, эмх цэгцийг хэмжих үнэлгээний хуудсыг шинэчлэн боловсруулах | | |
| 7. | Байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулах Цасны баярын удирдамж боловсруулах | 100 | 70 |
| 8. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн, цаашид нэвтрүүлэх үйлчилгээний жагсаалтыг тулгах, баталгаажуулах, зөрүүтэй мэдээллийг залруулах, жагсаалтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн даргаар ажиллан тушаалын хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 9. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/99 дүгээр тушаалаар байгуулагдсан Стратеги төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн гишүүнээр ажиллан тушаалын хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 10. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан Чиг үүргийн шинжилгээ боловсруулах Ажлын хэсгийг удирдан тушаалын хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 11. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/58 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах | 100 | 70 |
| 12. | Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн сургалт, нэвтрүүлэлт, үнэлгээ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны холбогдох удирдах албан хаагчдад танилцуулах | 100 | 70 |
| 13. | Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийг сайжруулах санал боловсруулж, Штабт хүргүүлэх | 100 | 70 |
| 14. | "Цахим хөгжлийн өдөрлөг" арга хэмжээг зохион байгуулах | 100 | 70 |
| 15. | "Цахим эрүүл мэнд" арга хэмжээнд газрын албан хаагчдыг оролцуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах | 100 | 70 |
| 16. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/35 дугаар тушаалаар байгуулагдсан Хуулийн багийн Ажлын хэсгийг удирдан тушаалын хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 17. | Төрийн цахим үйлчилгээг хороодоор үзүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээний төсөл, Казахстан улстай хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний илтгэх хуудсыг боловсруулах | 100 | 70 |
| 18. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/102 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 19. | Бүгд Найрамдах Казакстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн Тэргүүн дэд сайд, Бүгд Найрамдах Казакстан Улсын Хууль зүйн дотоод хэргийн Дэд сайд тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авах, холбогдох хурал, уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах | 100 | 70 |
| 20. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оролцох | 100 | 70 |
| 21. | Байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга бэлтгэх | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| 22. | Салбар дундын зохицуулалтын чиглэлээр байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, санал солилцох | 100 | 70 |
| 23. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/35 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах | 100 | 70 |
| 24. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар "Цахим аймаг" төслийн тоног төхөөрөмж (Дундговь) худалдан авах, төсөл арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой эрхийг Төрийн цахим үйлчилгээний газарт шилжүүлсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах | 100 | 70 |
| 25. | ТЦҮЗГ/20240102003 дугаар тендерийн гүйцэтгэлийг хүлээн авах агентлагийн даргын А/66 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 26. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/67 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах | 100 | 70 |
| 27. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр баталсан Нийслэлийн төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгт ажиллах албан хаагчдын хуваарийн дагуу ажиллах, газрын албан хаагчдыг ажиллах нөхцөл боломжоор хангах | 100 | 70 |
| 28. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд шинээр мэдээлэл хариуцагч байгууллагын 100 үйлчилгээг нэвтрүүлэх "Ухаалаг засаг 2" төслийн даалгаврыг боловсруулах | 100 | 70 |
| **Дундаж оноо:** | | | 70 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Удирдлагын академийн сургалтад хамрагдах | 66.6 % | 10 |
| 2. | Төрийн албаны зөвлөл болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах | 37.3 % | 5.6 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 7.8 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (7 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 |
| 4. | Манлайлах | 7 |
| 5. | Багаар ажиллах | 7 |
| 6. | Харилцаа | 7 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 7 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (8 хүртэл оноогоор) |
|---|---|---|

| | 1 | 2 |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо** | 8 |

5. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 70 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 7.8 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| | **Нийт оноо** = ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | 92.8. |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга ............................ /П.Батбаатар/
*2024.12.04*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

Чанар хяналтын газрын дарга ............................ /И.Хайратбек/
*2024.12.04*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ЧАНАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЧАНАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА ИШБЕК ОВОГТОЙ ХАЙРАТБЕКИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 1: ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, ХӨРӨНГӨ, НӨӨЦИЙГ ХУВААРИЛАН ЗОХИЦУУЛАХ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГ ЭРХЛЭХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 1.1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах** | | | | | | | |
| 1.1.1 | Салбарын бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох ажлын хэсэг, арга хэмжээнд оролцох, зохион байгуулах | Арга хэмжээ, ажлын хэсгийн тоо | 6 | 3 | “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтарсан орон нутгийн төрийн байгууллагын төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн үйлчилгээнд процессын шинжилгээ хийх, дахин загварчлах, шинээр цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний судалгааг гаргах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг;<br>Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02/327 дугаар албан бичгийн дагуу “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цахим хөгжлийн өдөрлөг” арга хэмжээ;<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 14 хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуу “Ногоон хэрэм” төслийн арга хэмжээ;<br>Төрийн бүтээмжийн сэргэлт - Цахим эрүүл мэнд арга хэмжээ;<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар байгуулагдсан Авлигатай тэмцэх “5Ш” ажиллагааны хүрээнд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий Штаб;<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/102 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ээр үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг;<br>“Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран “Цахимд зөв байя” уриатай цахим гэмт хэрэг, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ур чадварыг нэмэгдүүлэх сургалт арга хэмжээ.<br><br>Нийт 3 ажлын хэсэг, 4 арга хэмжээнд оролцож, зохион байгуулалтыг хангаж ажилласан. | | |
| 1.1.2 | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангах | Батлагдах журмын тоо | - | 2 | Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд “Хяналт шалгалтын журам”, “Бусдаар ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх журам”, Үндсэн болон дэмжих системийн гэмтэл, саатлын үед мэдээлэл солилцох, засварлах, хариу арга хэмжээ авах, тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмтэл, саатлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулах “Үндсэн болон дэмжих системийн гэмтэл, саатлын журам”-ын төслийг боловсруулан, газар, хэлтсийн дарга, | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Үндэсний дата төв" Улсын төсөвт үйлдвэрийн газар, "И-Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газраас холбогдох санал, процессын зураглалыг хүлээн авч, нийт 3 журмын төслийг боловсруулсан.<br>Газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журмын төслийг шинэчлэн боловсруулсан.<br><br>Нийт 4 журмын төсөл боловсруулсан. | | |
| 1.1.3 | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх | Саналын тоо | 2 | 2 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал" хэлэлцүүлэгт хамрагдсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/153 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас санал авах маягтын дагуу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал авах хүснэгтийн дагуу санал боловсруулж хүргүүлсэн.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр тус газрын даргын А/33 ажлын хэсгээр байгуулагдсан "Хуулийн баг"-аас боловсруулж, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br><br>Нийт 2 санал хүргүүлж, 1 хэлэлцүүлэгт оролцсон. | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | Агентлагийн даргын шуурхай хурлыг зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах | Хурлын тоо | 35 | 24 | Агентлагийн даргын шуурхай зөвлөгөөнд нийт 24 удаа оролцож, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийг тухай бүр танилцуулсан. | 100 | 01-12 |
| 1.1.5 | Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлах, эрсдэлийн үнэлгээ хийх | Үнэлгээний тоо | - | 1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд газраас хийж хэрэгжүүлсэн ажилд үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан.<br>Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааны хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201, 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мэдээлэл хариуцагч байгууллагын байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг нээлттэй мэдээллийн "Shilen.gov.mn" системд байршуулсан мэдээлэл хариуцагч 612 байгууллагын "Шилэн индекс"-ийн тайланг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэн, хянан баталгаажуулж, хэвлэн нийтэлж, "Shilen.gov.mn"-ийн 2.0 хувилбарын сургалтыг мэдээлэл хариуцагч байгууллагын 1950 төрийн албан хаагчдад цахим болон танхимаар зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөөгөөр ханган "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг ханган ажилласан.<br><br>Нийт 1950 албан хаагчдыг сургалтад хамруулсан. | 100 | 01-12 |
| 1.1.6 | Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Монгол Улсад орчин цагийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар үүсэж хөгжсөний түүхт 103 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны жуух бичгээр эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 4 албан хаагчийг тодорхойлж шагнуулсан.<br><br>Нийт 4 албан хаагчийг шагналд тодорхойлсон. | 100 | 01-12 |
| **Зорилт 1.2. Хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 1.2.1 | Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаараар болон бусад хэлбэрээр | Шийдвэрлэсэн тоо | 244 | 235 | Тайлант хугацаанд 7012-2626 тусгай дугаарт байршил, цагийн хуваарьтай холбоотой 273, | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх, хяналт тавих | | | | гомдол, хүсэлт 69, талархал 201, заавар, зөвлөгөө, мэдээлэл 182, бусад асуудлаар хандсан 199, нийт 924 хүн, хуулийн этгээдийн дуудлагыг авч, холбогдох байгууллага, газар, нэгжид асуудлыг уламжлан, зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.<br>Тайлант хугацаанд 7012-2626 дугаарт үйлчилгээний ажилтантай холбоотой 194 талархал ирснийг холбогдох нэгжийн удирдлага, тухайн албан хаагчид мэдэгдсэн. Иргэдээс иргүүлсэн талархлаас дурдвал:<br>*(2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Сүхбаатар аймгийн Хурдан цэгийн үйлчилгээний ажилтан Энхчимэг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад талархал илэрхийлье. Хурдан шуурхай, эелдэг найрсаг үйлчилгээ үзүүллээ, их сайхан санагдаж байна. Миний талархлыг заавал дамжуулж өгөөрэй. Та бүхний цаашдын ажилд нь амжилт хүсье. Иргэн Аюурбазар)*<br><br>*(Төв шуудангийн үйлчилгээний ажилтан О.Энхзаяад талархаж байна. Бид тэр болгон энэ үйлчилгээнүүдийг мэдэхгүй байдаг, чин сэтгэлээсээ төвөгшөөлгүй сайхан үйлчиллээ. Ийм сайхан үйлчилгээ үзүүлж байгаа танай газрын хамт олонд баярлалаа.)*<br><br>*(Төв аймгийн үйлчилгээний ажилтан Мөнхзаяад талархал илэрхийлж байна. Удаа дараа үйлчилгээ авсан, зан харилцаа хандлага болон үйлчилгээ үзүүлэх ур чадварын хувьд их сайхан харилцаатай. Баярлаж талархаж байгааг минь дамжуулаад өгөөрэй. Иргэн Саранчимэг)*<br><br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын цахим хуудасны санал, хүсэлтийн цэсэд нийт 17 иргэний иргүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч бүртгэн, холбогдох байгууллага, газар, нэгжид асуудлыг уламжлан хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт 941 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэсэн. | | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ, ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ, НЭГТГЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ ОНОВЧЛОХ, ЦАХИМЖУУЛАХ, СУДАЛГАА ХИЙХ, АЛБАН ХААГЧИЙГ САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ** | | | | | | | |
| **Зорилт 2.1. Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой системийг нэвтрүүлэх, зохицуулалт хийх, нэгтгэх, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, үйлчилгээг оновчлох, цахимжуулах, судалгаа хийх** | | | | | | | |
| 2.1.1 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, ХУРДАН цэгийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах | Цэгийн тоо | 144 | 156 | Төрийн цахим үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэж байгаа нийслэл, аймаг дахь 128 (давхардсан тоогоор) ХУРДАН цэг, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын 82 (давхардсан тоогоор) ХУРДАН цэг, Монгол шуудан ХК-ийн 70 (давхардсан тоогоор) салбар, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 11 (давхардсан тоогоор) салбар, 46 хорооны нийт 310 цэгийн мэдээллийн аюулгүй байдал (Компьютер, операторын системийн нууц үгээ сольсон эсэх, Microsoft office программын лицензтэй эсэх, албан ёсны сүлжээ ашигладаг эсэх), цэгүүдийн тоног, төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийж, заавар, зөвлөгөө өгч, 4 зөвлөмж хүргүүлж ажилласан.<br><br>Нийт 310 цэгийн мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. | 100 | 01-12 |
| 2.1.2 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (киоск)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах | Киоскийн тоо | - | 20 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03/1105 дугаар Чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн хүрээнд Киоск машины байршуулалт, үйлдлийн системд хяналт, шалгалт хийх чиг үүрэг бүхий ажлын хэсэг газрын даргын А/68 дугаар тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсгээс 9 удаа хурал, уулзалт зохион байгуулж, "Үндэсний дата төв" Улсын төсөвт үйлдвэрийн газраас ҮДТ/20240102025 дугаартай "Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх (Киоск)" ажил гүйцэтгүүлэх тендерт шалгарсан | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Гэрэгэ киоск” ХХК, “Топика” ХХК-ийн киоск машины хуваарилалт, байршуулсан байдал, гарч буй асуудлуудтай танилцаж, хяналт тавьж ажилласан.<br>Нийслэл, орон нутгийн хэмжээнд нийт 505 киоск машин байршуулахаас: нийслэлд 127, орон нутагт 84, *(тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан 22 киоск машин)*, хилийн боомтод 4 нийт 237 киоск машиныг байршуулан, киоск машинд 105 үйлчилгээг нэвтрүүлэхээр хөгжүүлэлт хийснээс 86 үйлчилгээ идэвхтэй, 19 үйлчилгээ идэвхгүй, нэршил зөрүүтэй засварлах 17, хууль журмын дагуу хасах 3 үйлчилгээ байна.<br>Төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх киоск машины үйлчилгээнд Е болон Ц ангилал, Нийслэлийн гудамж замын хөдөлгөөнд ачааны авто машиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрлийн системийн эх код авах тухай Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт цахим шуудан илгээж, “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газарт “Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх (киоск)” тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн киоск машины үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан ажлын товч тайлан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 03/1105 дугаар албан бичгийн дагуу мэдээлэл хүргүүлсэн тухай дүгнэлтийг “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газарт 2 удаа хүргүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 03/1105 дугаар албан бичгийн дагуу хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/371 дүгээр албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт 215 киоск байршуулсан. 86 үйлчилгээ идэвхтэй, 19 үйлчилгээ идэвхгүй төлөвтэй байна. | | |
| 2.1.3 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск), цахим лавлагааны систем, албан бичиг солилцооны систем, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгох систем, нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний систем, и-Монгол, и-бизнес платформ, нийтийн өргөдөл гомдлын систем, төлбөрийн систем, huduu.gov.mn гэх мэт системийн хөгжүүлэлт, сайжруулалтын талаар санал боловсруулах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах | Зөвлөгөө, мэдээллийн тоо | 401 | 300 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр үйлчилгээ үзүүлэх явцад үүссэн 506 алдаа доголдол (өссөн дүнгээр)-ыг шуурхай шийдвэрлэж заавар, зөвлөгөөг өгч ажилласан.<br>Операторын нэгдсэн бүлэгт нийслэл, орон нутгийн үйлчилгээний ажилтан, хилийн чанад дахь ХУРДАН цэгийн үйлчилгээний ажилтнуудаас ирүүлсэн үйлчилгээтэй холбоотой 31 асуултад хариу өгч, шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийг эрчимжүүлэх “Цахим үндэстэн” болох зорилтын хүрээнд төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн иргэдэд хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийг мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах ажлын хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Хан-Уул, Багахангай. Багануур, Налайх дүүргийн 14 хороонд байгуулагдсан “ХУРДАН” цэгийн нээлтийн үйл ажиллагаанд оролцож, төрийн цахим үйлчилгээ, түүний ач холбогдлын талаар 345 иргэдэд танилцуулж, нээлтэд оролцсон иргэдийн асуултад хариулан төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>Нээлттэй мэдээллийн “Shilen.gov.mn” системд “Шилэн индекс”-ийн үнэлгээ, харьяа болон салбар байгууллагуудын хэмжээнд “Шилэн индекс”-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, баталгаажуулах нээлттэй мэдээллийн дата оруулах, шинэчлэх зэрэг чиглэлээр утсаар, цахим хэлбэрээр, биечлэн нийт 1214 албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.<br><br>Нийт 1590 зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.4 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д дэд админ, операторын админ, операторын эрх нээх, цуцлах, хяналт тавих | Нээх, цуцлах эрхийн тоо | 275<br>32 | 375<br>82 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг ашиглах операторын 211 эрх нээж, 57 эрх цуцалсан байдалд хяналт тавьж ажилласан.<br>Үйлчилгээний ажилтны системд нэвтрэх эрх нээх, цуцлах хяналтын хүрээнд аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн 1 үйлчилгээний ажилтан, хилийн чанад дахь 2 цэгийн ажилтан, "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Зүүн бүсийн холбооны салбарын 1 ажилтан өмнөх ажилтны эрхээр нэвтэрч байсныг Гадаад харилцааны яамны Консулын газар, Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газарт газрын даргын 2024 оны 01/418 дугаар албан бичиг, Чанар хяналтын газрын 09 дүгээр албан бичгээр зөвлөмж хүргүүлж зөрчлийг арилгуулсан.<br><br>Нийт: 211 хэрэглэгчийн эрх нээж, 57 эрх цуцлахад хяналт тавьж, 3 зөрчлийг арилгуулсан. | 100 | 01-12 |
| 2.1.5 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д нэвтрүүлэх үйлчилгээг эрэмбэлэх, санал боловсруулах, үе шаттайгаар нэмэгдүүлэх | Байгууллагын тоо, үйлчилгээний тоо | 51<br>467 | 5<br>180 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан 785 үйлчилгээнээс Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр 43 байгууллагын 451 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа ба цахим хэлбэрт шилжүүлээгүй судлагдаж байгаа 24 байгууллагын 210 үйлчилгээ байна.<br>"Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-д үйлчилгээний нэр болон байгууллагын нэр зөрүүтэй байдлыг засварлаж, мэдээлэл хариуцагч байгууллагын ангилал, зэрэглэлээр эрэмбэлж тогтоолд өөрчлөлт оруулах талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2024 оны 01/153 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн.<br>Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д нэвтрүүлэх үйлчилгээг үе | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд 31 байгууллагаас төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэхээр санал ирүүлсэн 55 үйлчилгээнээс 1 үйлчилгээг нэвтрүүлж, 54 үйлчилгээг интеграци хийж үе шаттайгаар нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Ирүүлсэн саналын дагуу холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх боломжтой эсэхийг судлан, хөгжүүлэлт хийх асуудлаар "И Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газарт чиглэл хүргүүлж ажилласан.<br>Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, "И-бизнес", И-Монгол портал)-д цахим хэлбэрт шилжсэн 1086 үйлчилгээнд хяналт хийж үзэхэд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад шинээр нэмэгдэх боломжтой мэдээлэл хариуцагч 20 байгууллагын 133 үйлчилгээ, төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх санал ирүүлсэн 31 байгууллагын 54 үйлчилгээ, нийт 188 үйлчилгээг системд нэвтрүүлэх саналыг хүргүүлсэн.<br><br>Нийт: Санал 1, нэмэгдсэн үйлчилгээ 1 | | |
| 2.1.6 | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгт хяналтын систем нэвтрүүлэх | Системийн тоо | - | 1 | Үйлчилгээний ажилтны хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдалд хяналтын камераар хяналт, шалгалт хийх зорилгоор камер худалдан авах саналыг холбогдох газарт хүргүүлснээр нийт 70 камерыг аймаг, нийслэлийн Хурдан цэгт байршуулах ажлыг холбогдох газар, хэлтсүүд хийж гүйцэтгэсэн. Аймаг, Нийслэл дэх ХУРДАН цэгүүдийг хариуцан камераар хяналт хийх хуваарийг батлан, хуваарийн дагуу нийт 14 удаа хяналт тавьж, 7 зөрчлийг илрүүлэн тухай бүр холбогдох нэгжид танилцуулж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан. | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.2. Албан хаагчийг салбарын чиглэлээр сургах, мэргэшүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системийн талаарх сургалт зохион байгуулах, үр дүнг тайлагнах** | | | | | | | |
| 2.2.1 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | Хамрагдах хүний тоо | - | 500 | “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран “Цахимд зөв байя” уриатай цахим гэмт хэрэг, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 08, 10 дугаар сарын 13-ны өдрөөс 18-ны өдрүүдэд Дундговь, Өмнөговь, Архангай, Завхан, Увс, Хөвсгөл, Дархан Уул, Сэлэнгэ, Орхон, Булган аймгийн хэмжээнд зохион байгуулж, төрийн албан хаагч, ахмад настан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, нийт 7214 хүн хамрагдсан.<br>“Shilen.gov.mn”-ийн 2.0 хувилбарын сургалтыг 1950 төрийн албан хаагчдад зохион байгуулж, Шилэн индекс”-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, мэдээлэл шинэчлэх зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч ажилласан.<br><br>Нийт 9164 албан хаагч, иргэн, сурагч сургалтад хамрагдсан. | 100 | 01-12 |
| 2.2.2 | Албан хаагчийг салбарын чиглэлээр сургах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах | Албан хаагчийн тоо | - | 50 | Цахим хөгжил, харилцаа холбооны яаман дээр 2024 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн удирдах ажилтнуудад зориулсан сургалтын арга хэмжээнд “Хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах” сэдвээр сургалтыг 25, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д шинээр нэвтэрсэн үйлчилгээ болон үе шаттайгаар системд нэвтрүүлэх үйлчилгээ, төрийн үйлчилгээг операторын системээр үзүүлэхэд анхаарах асуудлууд сэдвээр сургалтыг 85 албан хаагчдад зохион байгуулж, нийт 110 албан хаагч хамрагдсан.<br>Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга, үйлчилгээний ахлах ажилтнуудад цахим болон танхимын хэлбэрээр нийт 5 удаа “Shilen.gov.mn”-ийн 2.0 хувилбарын | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтыг зохион байгуулж, Шилэн индекс"-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, мэдээлэл шинэчлэх зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч 110 (давхардсан тоогоор) албан хаагчийг хамруулсан.<br><br>Нийт 220 албан хаагч сургалтад хамрагдсан. | | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 3: УЛСЫН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХҮРГЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ОРОН НУТАГТ САЛБАРЫН БОДЛОГЫН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 3.1. Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг байгуулах, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах, орон нутагт салбарын бодлогын холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 3.1.1 | Төрийн цахим үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох судалгаа хийх | Судалгааны тоо | 4 | 1 | Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх судалгааг судалгааны MICG байгууллагаар гүйцэтгүүлэн, судалгааны үр дүнд тулгуурлан нийслэл, аймгийн хэмжээнд Төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт "ХУРДАН" цэг 2-ыг байгуулан, үйл ажиллагааг жигдрүүлэн ажилласан.<br>Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам"-ын 2.7 дахь хэсэгт "Хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем, төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машин болон хувийн хэвшлийн киоск машин, мэдээлэл хариуцагчийн системээр дамжуулан хүлээн авч болно." гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлд 127, орон нутагт 84, тусгай хэрэгцээт 22, нийт 237 киоск машиныг байршуулан, нийт 138470 хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэн ажилласан.<br>Төрийн байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээ, үйлчилгээний чиглэлийг тодорхойлох, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | загварыг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/67 дугаар тушаалаар байгуулж, 18 аймаг, 33 агентлагаас ирүүлсэн судалгааг нэгтгэх, танилцуулах ажлыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнгээр: Нийт 33 агентлагийн 755 үйлчилгээнээс: цахим хэлбэрт шилжүүлсэн 533 үйлчилгээ, бусад системд нэвтэрсэн 459 үйлчилгээ, цахим хэлбэрт шилжүүлээгүй 222 үйлчилгээ, төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн 202 үйлчилгээ байна. Нийт 18 аймгийн 7446 үйлчилгээнээс: цахим хэлбэрт шилжүүлсэн 3435 үйлчилгээ, бусад системд нэвтэрсэн 3469 үйлчилгээ, цахим хэлбэрт шилжүүлээгүй 4011 үйлчилгээ, төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн 572 үйлчилгээ байна.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/102 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 03/786 дугаар албан бичгээр ажлын хэсгээс хийх ажлыг бүрэн гүйцэтгэхэд холбогдох арга хэмжээг авах талаар чиглэл ирүүлсэн.<br>"И-Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газраас ирүүлсэн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (портал, аппликейшн)-ээс үзүүлж байгаа үйлчилгээг орон нутагт 1194 үйлчилгээ, нийслэлд 1610 үйлчилгээ болгож, дотор нь /0-5/ төрөлд ангилж, утга агуулга нэг үйлчилгээ олон янзаар бичигдэж, давхардсан бичвэрийн алдаатай, хасагдсан зэрэг алдааг төрлөөр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ялган хамгийн их, хамгийн бага авсан үйлчилгээ ялгах зэрэг судалгааны ажил хийгдэж байна.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс 2019 - 2024 оныг хүртэл 63 сая 493782 үйлчилгээ үзүүлснээс: гар утаснаас - 54785085, порталаас - 6706879, операторaас - 2001845 үйлчилгээг хүн, хуулийн этгээд авсан байна.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (Портал, аппилейкшн)-ээр үзүүлэх үйлчилгээг шивж, жагсаалт үйлдэн үйлчилгээний нэршлийг төрөлжүүлэн, утга агуулга нэг, давхардсан, алдаатай бичвэрийг залруулж, нийт 1170 үйлчилгээг ангилж, орон нутагт үзүүлж байгаа 256 үйлчилгээг 58 үйлчилгээ, нийслэлд үзүүлж байгаа 784 үйлчилгээг 95 үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олгох төрлийн 134 үйлчилгээг 78 үйлчилгээ болгон тоог цөөрүүлж, 400 гаруй үйлчилгээ болгох боломжтой талаар судалж, эхний байдлаар 5 байгууллагын 291 үйлчилгээг 21 төрлөөр ангилж, танилцуулга бэлтгэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон газрын удирдлагуудад танилцуулсан.<br>*Жишээлбэл: Хил хамгаалах ерөнхий газраас үзүүлэх 49 үйлчилгээг 4 төрлөөр, Улсын бүртгэлийн 70 үйлчилгээг Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл төрөлд хувааж (Иргэний улсын бүртгэлийн 31 үйлчилгээг 3 ангилж, Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн 27 үйлчилгээг 2 ангилж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 12 төрлийн лавлагааг 1 үйлчилгээ) ангилсан.* | | |
| 3.1.2 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2024 онд хамтрах ажиллах гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | Хэрэгжилтийн хувь | - | 70 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хамтрах ажиллах гэрээний зарим чиг үүргийн хэрэгжилтийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх ажлын удирдамжийг 2024 оны 09 дүгээр сарын өдөр 08-ны өдөр газрын даргаар батлуулан, 21 | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэст хүргүүлж, гэрээний хэрэгжилтийг дүгнэн зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан. Хэрэгжилтийг дүгнэж үзэхэд: Дорноговь, Орхон аймаг 90%-тай, Архангай, Баянхонгор, Дархан, Өмнөговь аймаг 80%-тай, Хэнтий, Өвөрхангай, Дундговь аймаг 70%-тай, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Баян-Өлгий, Говь-Алтай аймаг 60%-тай, Сүхбаатар, Говьсүмбэр аймаг 50%-тай, Төв аймаг 23%-тай хувь байгаа бөгөөд Увс, Ховд, Завхан, Дорнод зэрэг 4 аймгийн ирүүлсэн тайлан нь үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хамтрах ажиллах гэрээний 2 дугаар зүйлийн "Цахим засаглалыг бэхжүүлэх чиглэлээр" хэсгийн 2.1.2.1. 2.1.2.5. заалтын хэрэгжилтийг гарган Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газарт хүргүүлсэн. | | |
| 3.1.3 | Орон нутагт харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим засаглал, нийтийн мэдээллийн дэд бүтэц, кибер аюулгүй байдал, цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах, салбарын хүний нөөцийн хөгжил, салбарын мэргэжлийн хяналтын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | Хэрэгжилтийн хувь | - | 100 | "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран цахим гэмт хэрэг, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг Дундговь, Өмнөговь, Архангай, Завхан, Увс, Хөвсгөл аймгийн хэмжээнд зохион байгуулж, төрийн албан хаагч, ахмад настан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, нийт 1743 хүнийг зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02/327 дугаар албан бичгийн дагуу "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс зэрэг нийт 11 аймгийн | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлага, харилцаа холбооны салбарын байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, Улсын Их хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр санал танилцуулж, уулзалтад нийт 25 удирдах албан тушаалтнууд оролцсон. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран “Цахимд зөв байя” уриатай цахим гэмт хэрэг, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 08, 10 дугаар сарын 13-ны өдрөөс 18-ны өдрүүдэд Дундговь, Өмнөговь, Архангай, Завхан, Увс, Хөвсгөл, Дархан Уул, Сэлэнгэ, Орхон, Булган аймгийн хэмжээнд зохион байгуулж, төрийн албан хаагч, ахмад настан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, нийт 7214 хүн хамрагдсан.<br>Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийг сайжруулах саналыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар байгуулагдсан “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг хангах Штаб, Аствишн ХХК-д хүргүүлсэн.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг хөгжүүлэх, алдаа доголдлыг сайжруулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд санал оруулсан.<br><br>Нийт 7214 хүн сургалтад хамрагдсан. | | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 4: ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН ХҮРГЭЖ БАЙГАА ЭСЭХЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 4.1. Холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Үйлчилгээний ажилтны үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох байгууллагад тайлан хүргүүлэх | Тайлангийн тоо | - | 1 | Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны 01/276 дугаар албан бичгийн дагуу байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа Монгол Улсын MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021, MNS 6984:2022 стандартуудын 2023, 2024 оны 1 дүгээр улирлын тайланг нэгтгэн гаргаж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/102 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Чанар хяналтын газраас 2023 онд хийсэн хяналт, шалгалтын ажлын нэгдсэн тайланг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 01/25 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br><br>Нийт 2 тайлан хүргүүлсэн. | 100 | 01-12 |
| 4.1.2 | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж хүргүүлэх | Хяналт шалгалтын тоо, зөвлөмжийн тоо | 25<br>18 | 45<br>20 | Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа нийслэлийн 12, аймгийн 33, хилийн чанад дахь 42, нийслэлийн хороодын 27, нийт 310 (давхардсан тоогоор) ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, ажил сайжруулах 26 удаагийн зөвлөмж хүргүүлэн, хяналт, шалгалтын үр дүнг холбогдох нэгжүүдэд танилцуулан шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу аймаг, нийслэлийн ХУРДАН цэгийн үйлчилгээний ахлах ажилтан, үйлчилгээний ажилтан, нийт 41 ажилтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютер, тоног төхөөрөмжид хяналт, шалгалт хийсэн. Уг хяналт, шалгалтаар холбогдох хууль, журмаар хориглосон сайтад нэвтрэн кино, бичлэг үзсэн, хүн, хуулийн этгээдийн хувийн мэдээллийг хадгалсан зэрэг зөрчлийг холбогдох нэгжид | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. | | |
| **Зорилт 4.2. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг шинжлэх** | | | | | | | |
| 4.2.1 | Үйлчилгээний цэгийн байршлын хүртээмжийг сайжруулах талаар судалгаа хийх, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх | Дүгнэлт, зөвлөмжийн тоо | 2 | 6 | Үйлчилгээний цэгийн байршлын хүртээмжийг тодорхойлох зорилгоор судалгааны MICG байгууллагатай хамтран Нийслэл, орон нутгийн ХУРДАН цэгийн үйлчилгээний ажилтнуудын ажлын ачаалал, үйлчлүүлэгчийн ашиглалтын зорилго, үзүүлсэн үйлчилгээ, салбарын ачаалал, хугацаа, байршил зэрэг 6 үзүүлэлтээр судалгаа хийсэн.<br>Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа нийслэлийн 12 ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд нийт 4 удаа хяналт шалгалт хийж, хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 5 үйлчилгээний цэгийн байршлыг өөрчлөх талаар 4 удаагийн зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлэн, 3 цэгийн байршлыг өөрчлөх арга хэмжээг хариуцсан нэгжээс авч, нийслэлийн хэмжээнд 19 ХУРДАН цэг үйл ажиллагаа явуулж байснаас өнөөдрийн байдлаар 13 цэг хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна. | 100 | 01-12 |
| 4.2.2 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ээр төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашгийн шинжилгээ хийх | Арга хэмжээний тоо | - | 1 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэснээр нийгэм, эдийн засагт гарах үр ашгийн судалгааны асуумж боловсруулах зорилгоор олон улсын туршлагыг судалж, судалгааны аргыг тодорхойлон асуумж боловсруулсан. Тус асуумжийн хүрээнд нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашгийн шинжилгээ хийхээр төлөвлөн ажиллаж байна. | 60 | 01-12 |
| Зорилт 4.3. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ийн үйл ажиллагаанд хяналт тавих | | | | | | | |
| 4.3.1 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ийн алдаа, доголдлыг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагад мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах | Мэдэгдлийн тоо | - | 12 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр 2024 онд хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх явцад системтэй холбоотой гарсан 560 алдааг түүвэрлэж, нэгтгэлийг гарган 7 хоног бүр асуудал хариуцсан нэгж, байгууллагад хүргүүлж, алдааг арилгуулах арга | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд илэрсэн алдаа, доголдлыг "И Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газрын Систем нэгтгэлийн газар, Салбар дундын зохицуулалтын газрын холбогдох албан хаагчдад 12 удаа мэдэгдэн, түүвэрлэсэн алдааны нэгтгэлийг гарган хүргүүлж ажилласан.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 01/06, 04/433 дугаар Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай албан бичгийг "И-Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газарт хүргүүлсэн.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр үзүүлэх үйлчилгээг "Гэрэгэ киоск" ХХК киоск машинд нэвтрүүлэх ажлын хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэх 105 үйлчилгээг гэрээний дагуу нэвтрүүлсэн байдалд 2 удаа хяналт, шалгалтыг хийхэд киоск машинд 86 үйлчилгээ идэвхтэй, 19 үйлчилгээ идэвхгүй, мөн хууль, тогтоол, журмын өөрчлөлтийн дагуу хасах шаардлагатай 2 үйлчилгээ байна. Түүврийн аргаар үйлчилгээнүүдийг турших үзэхэд лавлагаа, тодорхойлолт хэсэгт хэрэглэгчийн дугаар, нэгж талбарын дугаар шаардаж цааш үйлчилгээ авах боломжгүй болдог. Үйлчлүүлэгч киоск машинаас үйлчилгээ авч дуусаад үргэлжлүүлэн дараагийн үйлчлүүлэгч үйлчилгээ авахад өмнөх хүний мэдээлэл хэвээр *(дэлгэцэд хадгалагдаж үлддэг)* хадгалагддаг алдаа, доголдлууд илэрсэн.<br>Ажлын хэсгээс Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газар, Гэрэгэ киоск ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хамтарсан уулзалт зохион байгуулж, киоск машинд үйлчилгээний нэршил давхардсан, бичвэрийн алдаатай, мэдээллийн зөрүүтэй, төрийн байгууллагын нэр хуучнаар тусгагдсан зэрэг алдаа, доголдлыг засварлаж, киоск машины хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт 583 алдаа, доголдлыг илрүүлэн арилгуулах арга хэмжээг авч ажилласан. | | |
| 4.3.2 | Үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх ур чадварт хяналт тавих | Үйлчилгээний ажилтны тоо | - | 106 | Тайлант хугацаанд нийт 450 (давхардсан тоогоор) үйлчилгээний ажилтны хандлага, харилцаа, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт, шалгалт хийж, үйлчилгээний ажилтнууд тоон гарын үсгээр үйлчилгээ үзүүлж чадахгүй, төлбөр тооцооны төхөөрөмж ажиллуулж чадахгүй, тоног, төхөөрөмжтэй ажиллах ур чадвар хангалтгүй байсан зэрэг илэрсэн зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллага, нэгжид 5 удаа зөвлөмж хүргүүлж, зөрчлийг арилгасан эсэхэд гүйцэтгэлийн хяналт, шалгалт хийж ажилласан. | 100 | 01-12 |
| **Зорилт 4.4. Үйлчилгээний ажилтны шалгуур үзүүлэлтийг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих** | | | | | | | |
| 4.4.1 | Ажлын байранд тавигдах шаардлага, үйлчилгээний ажилтны хандлага, харилцаа, үйлчилгээ үзүүлэх ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж батлах | Баримт бичгийн тоо | 1 | 3 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам"-ын:<br>• ажлын байранд тавигдах тохижилт, тоног төхөөрөмж, нэмэлт хэрэгсэл, үйлчилгээний ажилтны хувцасны стандартад тавигдах 4 бүлгийн 49 шаардлага<br>• цэгийн эмх цэгц, хэвийн үйл ажиллагааг үнэлэх үйлчилгээний цэгийн үзэмж, тохижилт, үйлчилгээний салбарын цэвэрлэгээ, мэдээллийн самбар зэрэг 3 бүлгийн 10 үзүүлэлт<br>• үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх харилцах ур чадвар, хандлага үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх 4 бүлгийн 11 үзүүлэлт, нийт 70 шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, газар, хэлтсийн дарга нараас санал авч, тушаалын төслийг боловсруулсан. | 90 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.2 | Мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдтэй хамтран ажиллаж, зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | Тайлангийн тоо | - | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/30, А/148 дугаар тушаалаар батлагдсан "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"-ын дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/98 дугаар тушаалаар тус газрын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх "ХУРДАН" цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэж гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хүрээнд Проектив солюшанс ХХК-тай гэрээ байгуулан мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.<br>Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001, Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус газрын 9 албан хаагч дотоод аудитор бэлтгэх сургалтад хамрагдсан. | 80 | 01-12 |
| 4.4.3 | Олон улсын стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах | Дүрэм, журмын тоо | - | 2 | MNS 6984:2022 "Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих шаардлага"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журмыг шинэчлэн боловсруулсан.<br>MNS 6984:2022 "Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих шаардлага" стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийт 310 (давхардсан тоогоор) ХУРДАН цэгийн ажлын байранд тавигдах шаардлага, 406 (давхардсан тоогоор) | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлж байгаа байдал, харагдах байдал, эмх цэгцэд хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр холбогдох нэгжид хүргүүлэн арилгуулах арга хэмжээг ажилласан.<br>Төрийн цахим үйлчилгээ зохицуулалтын газар, Олон Улсын менежментийн системийн зөвлөх үйлчилгээний "Ай Эм Эс Эй" ХХК-тай Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001, Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартад шаардлагатай баримт бичгийг боловсруулах, хамтран ажиллах ажлын төлөвлөгөө батлан, төлөвлөгөөний дагуу салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг, байгууллагын хэмжээнд боловсруулан мөрдөж байгаа дүрэм, журмыг "Ай Эм Эс Эй" ХХК-д хүргүүлсэн. | | |
| **Зорилт 4.5. Төрийн үйлчилгээний процессыг оновчлох, дахин загварчлах, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, хяналт тавих** | | | | | | | |
| 4.5.1 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлтийн оруулах санал боловсруулах, хүргүүлэх | Хүргүүлсэн саналын тоо | - | 1 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд 2024 оны байдлаар идэвхтэй мэдээлэл хариуцагч 43 байгууллагын 451 үйлчилгээ, идэвхгүй 75 үйлчилгээ, цахим хэлбэрт шилжүүлээгүй судлагдаж байгаа 24 байгууллагын 210 үйлчилгээ байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-д ороогүй боловч Төрийн цахим үйлчилгээний систем (оператор, И-бизнес, И-Монгол портал)-д цахим хэлбэрт байгаа 1086 үйлчилгээг шалгахад мэдээлэл хариуцагч байгууллагаас шинээр нэмэгдэх 20 байгууллагын 133 үйлчилгээ байна.<br>Шинээр цахим хэлбэрт шилжүүлэх санал гаргасан 6 байгууллагын 31, Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн 20 | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын 133 үйлчилгээ, нийт 25 байгууллагын 164 үйлчилгээг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад нэмж оруулах боломжтой гэж дүгнэн, Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-д нэмж, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан ажлын тайланг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/153 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-ын хүрээнд төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д нэвтэрсэн, цаашид нэвтрүүлэх үйлчилгээний жагсаалтыг тулгах, баталгаажуулах, зөрүүтэй мэдээллийг залруулах, жагсаалтыг шинэчлэн боловсруулах чиглэлээр Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хийсэн ажлын тайланг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон холбогдох албан хаагчдад танилцуулах арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харилцан санал солилцсон. | | |
| 4.5.2 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр мэдээлэл хариуцагч байгууллагатай хамтран ажиллах | Байгууллагын тоо | 26 | 40 | Цахим хэлбэрт шилжүүлэх боломжгүй үйлчилгээний талаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, "И-Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газарт ирүүлсэн саналыг үндэслэн мэдээлэл хариуцагч 15 байгууллагын 58 үйлчилгээний шалтгаан нөхцөлийг тодруулах зорилгоор мэдээлэл хариуцагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, 9 байгууллагын 34 үйлчилгээг | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой, 9 байгууллагын 24 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх боломжгүй болохыг уулзалтын явцад тодорхойлж, тухайн байгууллагуудаас албан бичгээр санал авч баталгаажуулсан.<br>Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д 12 байгууллагаас төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэхээр санал ирүүлсэн 55 үйлчилгээнээс 1 үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлж, 54 үйлчилгээг интеграци хийж үе шаттайгаар нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж, холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх боломжтой эсэхийг судлан, хөгжүүлэлт хийх асуудлаар "И Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газарт чиглэл хүргүүлэн ажилласан. | | |
| 4.5.3 | Төрийн үйлчилгээний процессыг оновчлох, дахин загварчлах, цахимжуулах ажлын хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах | Байгууллагын тоо | - | 5 | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүнд суртлыг бууруулах зорилтын хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв Улсын төсөвт үйлдвэрийн газар, "Систем арт венчурс" ХХК-тай хамтран Жижиг, дунд үйлдвэрийн газрын хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин загварчлал хийж үйл ажиллагааг нь оновчлох, лавлагаа, тодорхойлолт, олон шатлалт үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх, хамтран ажиллах ажлын хүрээнд газрын даргын 2024 оны А/34 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажилласан.<br>Жижиг, дунд үйлдвэрийн газрын төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, үйл ажиллагаанд дагаж мөрддөг дүрэм, журам, стратеги төлөвлөгөөний процессын зураглалыг хийж, бизнес процессын өнөөгийн нөхцөл байдлын тайлан, цаашдын үйл ажиллагаанд | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баримтлах загварыг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>“Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран орон нутгийн төрийн байгууллагын төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia-д нэвтэрсэн үйлчилгээнд процессын шинжилгээ хийх, дахин загварчлах, шинээр цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний судалгааг гаргах ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллан, аймаг дахь төрийн захиргааны 25 агентлагийн үзүүлж байгаа цахим хэлбэрт шилжүүлсэн төрийн үйлчилгээний нөхцөл байдлын шинжилгээ хийх, ашиглаж буй системүүдийн судалгааг авах, цахим үйлчилгээ, сэтгэл ханамжийн судалгаа авах, ахмадуудад зориулсан сургалт зохион байгуулах, байгууллагуудын олон шатлалт үйлчилгээний сайжруулалт хийх, хуучин үйлчилгээний систем дэх өөрчлөлт хийх, шинээр нэвтрэх үйлчилгээ судлах бодлогын даалгавар боловсруулах, сумдын үйлчилгээний ажилтнуудад сургалт хийх, ERP/DOCX сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан.<br>Стандарт, хэмжил зүйн газартай хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин загварчлал хийж үйл ажиллагааг нь оновчлох, лавлагаа, тодорхойлолт, олон шатлалт үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| 4.5.4 | Үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх санал боловсруулах | Хяналтын тоо | - | 4 | Үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх санал боловсруулах ажлын хүрээнд судалгааны MICG байгууллагатай хамтран Нийслэл, орон нутгийн үйлчилгээний ажилтнуудын ажлын ачаалал, үйлчлүүлэгчийн ашиглалтын зорилго, үзүүлсэн үйлчилгээ, | 90 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | салбарын ачаалал, хугацаа, байршил зэрэг 6 үзүүлэлтээр судалгаа хийсэн.<br>Нийслэлийн хэмжээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар байрлах Хурдан цэг 11%, Төв шууданд байрлах Хурдан цэг 30%, нийт 41% буюу хамгийн их ачаалалтай байна.<br>Жилийн 52 долоо хоногоор авч үзэхэд хугацааны хувьд 3 дугаар сар харьцангуй ачаалал багатай байдаг бол 10 дугаар сард үйлчилгээний ачаалал хамгийн их байна.<br>Судалгааны үр дүнгээс харахад нийслэлийн үйлчилгээний ажилтнуудын ажлын ачаалал их байдаг хэдий ч цэгийн байршлаас шалтгаалан харилцан адилгүй байна. Орон нутгийн хувьд авч үзэхэд жилийн зарим сард үйлчлүүлэгчгүй, зарим сард үйлчлүүлэгч тасралтгүй ирэх зэргээр ачаалал харилцан адилгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа нь үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна. | | |
| 4.5.5 | Төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системд мэдээлэл байршуулах, хяналт тавих (huduu.gov.mn, shilen.gov.mn) | Байгууллагын тоо | - | 21 | Монгол Улсын Засгийн газрын "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоолын дагуу Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Шил" ажиллагааны хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудаст нийтэд ил тод байхаар заасан мэдээллүүдийг нээлттэй болгон Shilen.gov.mn-д байршуулах ажлыг аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгуулж, мэдээлэл дутуу 56-75 оноотой 12 аймгаас 9 аймгийг 82-100 оноотой болгож мэдээллийг гүйцээж, Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д нийтэлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын "Шил" ажиллагааны хүрээнд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газар, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн харьяа газар, хэлтсийн нийт 1950 албан хаагчдыг | 100 | 01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулан Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар дахь "Шилэн индекс"-ийн үнэлгээ, харьяа болон салбар байгууллагуудын хэмжээнд "Шилэн индекс"-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, баталгаажуулах, мэдээлэл шинэчлэх зэрэг сэдвүүдээр нээлттэй мэдээллийн систем ("shilen.gov.mn")-ийн 2.0 хувилбарын сургалтыг зохион байгуулсан.<br>Нийтийн мэдээллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч байгууллагын байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг нээлттэй мэдээллийн "Shilen.gov.mn" системд байршуулсан мэдээлэл хариуцагч 612 байгууллагын "Шилэн индекс"-ийн тайланг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэн, хянан баталгаажуулж, хэвлэн нийтэлсэн.<br>Нээлттэй мэдээллийн систем ("shilen.gov.mn")-д төрийн байгууллагуудын байршуулсан нээлттэй мэдээллийг үнэлэх, баталгаажуулж, хэвлэн нийтлэх асуудлаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар байгуулагдсан Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааны хүрээнд "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий Штаб, Аствишн ХХК-ийн удирдлага болон холбогдох албан хаагчидтай 2024 оны 05 дугаар сарын 31, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр уулзалт зохион байгуулж, системд гарч байгаа алдаа доголдлыг арилгах, сайжруулах арга хэмжээний талаар харилцан санал солилцсон.<br><br>Нийт 1950 албан хаагчдыг сургалтад хамруулж, 1214 албан хаагчдыг зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.6 Үйл ажиллагааг зохион байгуулах, өөрийн газрын хариуцсан чиг үүргийн хүрээнд удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд гүйцэтгэх** | | | | | | | |
| 4.6.1 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | Архивд шилжүүлсэн баримтын тоо | - | 2 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, "Архивын үйл ажиллагаанд мөрдөх журам"-ыг мөрдөж ажиллан, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд 3 баримтыг хүлээлгэн өгсөн. 2024 оны байдлаар төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системээр ирсэн 31 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн, 31 байгууллагад албан бичгээр хариуг хүргүүлсэн ба газрын холбогдох нэгжүүдэд үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 15 дотоод албан бичгийг хүргүүлсэн. | 100 | 01-12 |
| 4.6.2 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | - | 100 | 2024 оны байдлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг тухай бүр гарган, танилцуулж ажилласан. | 100 | 01-12 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулах | Батлуулсан удирдамжийн тоо | 4 | 2 | Хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж байгаа аймаг дахь ХУРДАН цэг, Монгол шуудан ХК, Монголын цахилгаан холбоо ХК-ийн салбарын үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын удирдамжийг боловсруулан 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр батлуулсан. | 01-06 | 100 |
| 2. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2024 онд хамтрах ажиллах гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх удирдамж боловсруулж, батлуулах | Батлуулсан удирдамжийн тоо | - | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хамтрах ажиллах гэрээний зарим чиг үүргийн хэрэгжилтийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх ажлын удирдамжийг 2024 оны 09 дүгээр сарын өдөр 08-ны өдөр газрын даргаар батлуулан, 21 аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэст хүргүүлж, гэрээний хэрэгжилтийг дүгнэн зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Хэрэгжилт: 90%-тай Дорноговь, Орхон аймаг, 80%-тай Архангай, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Баянхонгор, Дархан, Өмнөговь аймаг, 70%-тай Хэнтий, Өвөрхангай, Дундговь аймаг, 60%-тай Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Баян-Өлгий, Говь-Алтай аймаг, 50%-тай Сүхбаатар, Говьсүмбэр аймаг, 23%-тай Төв аймаг хэрэгжилтийн хувьтай байгаа бөгөөд Увс, Ховд, Завхан, Дорнод зэрэг 4 аймгийн ирүүлсэн тайлан нь үнэлгээ өгөх боломжгүй байна. | | |
| 3. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэж байгаа хилийн чанад дахь "ХУРДАН" цэгийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн хяналт, шалгалтын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулах | Тайлан, зөвлөмжийн тоо | - | 1 | Гадаад харилцааны яамны консулын газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хамтран баталсан удирдамжийн дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэж байгаа хилийн чанад дахь "ХУРДАН" цэгийн үйл ажиллагаанд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн хяналт, шалгалтын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг Гадаад харилцааны яамны Консулын газарт Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/418 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 4. | Газрын ажилтнуудаас нийт албан хаагчдад сургалт хийх төлөвлөгөөг нэгтгэн Захиргаа удирдлагын газарт хүргүүлэх | Төлөвлөгөөний тоо | - | 1 | Цахим засаглалын тухай, Хүний эрхийн тухай ойлголт, Оюуны өмчийн тухай ойлголт, Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлт, Захиргааны тухай ойлголт сэдвээр газрын ажилтнуудаас зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг нэгтгэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр холбогдох нэгжид хүргүүлсэн. | 01-06 | 100 |
| 5. | Байгууллагад мөрдөгдөж байгаа стандартуудын тайланг авч нэгтгэн Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлэх | Тайлангийн тоо | - | 1 | Байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөж байгаа Монгол Улсын MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021, MNS 6984:2022 стандартуудын 2023, 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтийг гарган 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/102 | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаар албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн.<br>Стандарт, хэмжил зүйн газартай 3 удаагийн уулзалт зохион байгуулж, тус байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлдэг 6600 орчим И стандартыг төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлж, салбар дундын зохицуулалтыг хангаж ажилласан.<br>Стандарт, хэмжил зүйн газартай хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин загварчлал хийж үйл ажиллагааг нь оновчлох, лавлагаа, тодорхойлолт, олон шатлалт үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| 6. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам, ажлын байранд тавигдах шаардлага, үнэлгээний хуудас, үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг хэмжих үнэлгээний хуудсыг шинэчлэн боловсруулах | Журмын тоо | 1 | 1 | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журмыг шинэчлэн боловсруулах саналыг боловсруулан газар, хэлтсийн дарга нараас санал авч, хуулийн багт хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 7. | Байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулах Цасны баярын удирдамж боловсруулах | Удирдамжийн тоо | - | 1 | Байгууллагын ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах Цасны баярын удирдамж, хөтөлбөрийг боловсруулан газрын даргад танилцуулсан. Цаг агаарын байдал болон цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан уг арга хэмжээ цуцлагдсан. | 01-03 | 100 |
| 8. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн, цаашид нэвтрүүлэх үйлчилгээний жагсаалтыг | Тайлангийн тоо | - | 1 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, портал)-д цахим хэлбэрт шилжсэн хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тулгах, баталгаажуулах, зөрүүтэй мэдээллийг залруулах, жагсаалтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн даргаар ажиллан тушаалын хэрэгжилтийг хангах | | | | захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-д нэмж, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан ажлын тайланг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/153 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | | |
| 9. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/99 дүгээр тушаалаар байгуулагдсан Стратеги төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн гишүүнээр ажиллан тушаалын хэрэгжилтийг хангах | Зөвлөмжийн тоо | - | 1 | "Алсын хараа- 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлын хэсгийг газрын даргын 2023 оны А/99 дүгээр тушаалаар байгуулсан. Тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Удирдлагын хөгжил судлалын академи" ТББ-ын төлөөлөлтэй 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хамтарсан уулзалт зохион байгуулж, тус байгууллагаас ажлын хэсгийн гишүүд, газрын нэгжийн удирдлагуудад стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, стратеги төлөвлөгөөний орчны шинжилгээ хэрхэн хийх талаар танилцуулга хийсэн.<br>Тус газрын албан хаагчид асуудлын модны шинжилгээ, SWOT, PESTEL, Мексоны шинжилгээний аргуудаар авсан асуумжийг нэгтгэн Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 01-12 | 80 |
| 10. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан Чиг үүргийн шинжилгээ боловсруулах Ажлын хэсгийг удирдан тушаалын хэрэгжилтийг хангах | Шинжилгээний тоо | - | 1 | Байгууллагын бүтэц, албан тушаалын чиг үүргийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлыг бусад этгээдээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын 2024 | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/69 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсгийг Чанар хяналтын газрын дарга удирдан, 12 удаагийн хурал зохион байгуулж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын А/69 дүгээр албан бичгээр байгууллагын Чиг үүргийн шинжилгээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | | |
| 11. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/58 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах | Үнэлгээний тоо | 2 | 2 | Албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас болон жилийн эцсийн биелэлт, үр дүн, мэргэшлийн түвшинг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв, бодитой үнэлсэн эсэхэд хяналт тавьж ажилласан. | 06-12 | 100 |
| 12. | Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн сургалт, нэвтрүүлэлт, үнэлгээ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны холбогдох удирдах албан хаагчдад танилцуулах | Танилцуулгын тоо | - | 1 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас Нээлттэй мэдээллийн системд мэдээлэл хариуцагч байгууллагуудын нийтэлсэн ил тод, нээлттэй мэдээллийн өнөөгийн байдал, хэрэгжүүлсэн ажил, тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2024 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны сайдын зөвлөх М.Тулгат, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Бат-Өлзий нарын холбогдох албан хаагчдад танилцуулсан. | 01-12 | 100 |
| 13. | Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийг сайжруулах санал боловсруулж, Штабт хүргүүлэх | Саналын тоо | - | 1 | Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийг сайжруулах саналыг нээлттэй мэдээллийн систем (back-office, front-office)-ийг сайжруулах ажлын хүрээнд, нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийг хүн, хуулийн этгээдэд үзүүлэх талбарыг сайжруулах, хөгжүүлэх ажлын хүрээнд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн 3 чиглэлийн 23 арга хэмжээ бүхий саналыг боловсруулан Шил ажиллагааны хэрэгжилтийг хангаан ажиллах Штабт хүргүүлэн танилцуулах ажлыг зохион байгуулсан. | 11-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14. | “Цахим хөгжлийн өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээний тоо | | 11 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02/327 дугаар албан бичгийн дагуу “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс зэрэг нийт 11 аймагт “Цахим хөгжлийн өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Чанар хяналтын газрын дарга И.Хайратбек, мэргэжилтэн Ц.Борхүүхэн нар ажилласан. | 01-12 | 100 |
| 15. | “Цахим эрүүл мэнд” арга хэмжээнд газрын албан хаагчдыг оролцуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах | Арга хэмжээний тоо | - | 1 | Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд систем хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яамтай хамтран 2024 оны 05 дугаар сарын 02-12-ны өдрүүдэд зохион байгуулсан “Цахим эрүүл мэнд” сургалтад хамрагдсан. Тус сургалтын танилцуулгыг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 21 аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга нарт танилцуулсан. | 01-12 | 100 |
| 16. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/35 дугаар тушаалаар байгуулагдсан Хуулийн багийн Ажлын хэсгийг удирдан тушаалын хэрэгжилтийг хангах | Арга хэмжээний тоо | - | 2 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын тушаалаар хуулийн баг, судалгааны баг байгуулагдан ажиллаж байна. Хуулийн багийн ажлын хэсэгт тус газрын дарга болон мэргэжилтэн орж ажиллан 18 удаагийн 28 цагийн уулзалт зохион байгуулж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт холбогдох Шүүхийн маргааны талаар (Р.А) | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | асуудлыг хэлэлцэж, зураг төсөл, нууц, түрээс, ажил гүйцэтгэх, үнэ тариф тогтоох, төлбөр тооцоо хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний төслүүдийг эцэслэн боловсруулсан. Мөн дотоод үйл ажиллагаанд мөрдөх байгууллагын дотоод журам, цаг бүртгэл, зайнаас ажиллах, цалин хөлс олгох журам, нийгмийн баталгааны хөтөлбөрийн төслийг хянаж эцэслэсэн.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | | |
| 17. | Төрийн цахим үйлчилгээг хороодоор үзүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээний төсөл, Казакстан улстай хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний илтгэх хуудсыг боловсруулах | Саналын тоо | - | 2 | Төрийн цахим үйлчилгээг хороодоор үзүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээний төсөл болон Казакстан улстай хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний илтгэх хуудас зэргийг эцэслэн боловсруулж Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 18. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/102 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах | Тайлангийн тоо | - | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/102 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээний нэгдсэн систем дээр байгаа үйлчилгээг нягтлах ажлыг хийж гүйцэтгэж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 03/786 дугаар албан бичгээр ажлын хэсгээс хийх ажлыг бүрэн гүйцэтгэхэд | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох арга хэмжээг авах талаар чиглэл ирүүлсэн. | | |
| 19. | Бүгд Найрамдах Казакстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн Тэргүүн дэд сайд, Бүгд Найрамдах Казакстан Улсын Хууль зүйн дотоод хэргийн Дэд сайд тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авах, холбогдох хурал, уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах | Арга хэмжээний тоо | - | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран Бүгд Найрамдах Казакстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн Тэргүүн дэд сайд, Бүгд Найрамдах Казакстан Улсын Хууль зүйн дотоод хэргийн Дэд сайд тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авах, холбогдох хурал, уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан ба төлөөлөгчид Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагаа, төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй танилцсан.<br>Бүгд Найрамдах Казакстан Улсын "Үндэсний мэдээллийн технологи" ХК-тай мэдээлэл харилцаа, холбооны технологийн салбарт хамтран ажиллах санамж бичиг зурах ажлыг зохион байгуулсан. | 01-12 | 100 |
| 20. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оролцох | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Чанар хяналтын газрын албан хаагчид Хан-Уул дүүргийн 14 хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуу "Ногоон хэрэм" төслийн байршилд хайлаас, хүрэн монос, шар хайлаас, бургас, гацуур модны үрсэлгээ, тарьц суулгахад оролцон, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулсан. | 01-12 | 100 |
| 21. | Байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга бэлтгэх | Танилцуулгын тоо | - | 1 | Төрийн цахим зохицуулалтын газрын үйл ажиллагаатай Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал танилцаж, байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн. | 01-12 | 100 |
| 22. | | Танилцуулгын тоо | - | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх (орон тооны бус) М.Сайнбаяртай Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын удирдлага болон албан хаагчид 2024 оны 11 дүгээр сарын 19- | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ний өдөр төрийн үйлчилгээний талаарх асуудлаар уулзалт хийсэн. Тус уулзалтын хүрээнд цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцсон. | | |
| 23. | Салбар дундын зохицуулалтын чиглэлээр байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, санал солилцох | Уулзалтын тоо | 15 | 1 | Starlink nomad ХХК-ийн төлөөлөлтэй уулзаж, тус газрын шинээр үйлчилгээнд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа явуулын ХУРДАН цэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах боломжтой эсэх талаар харилцан санал солилцсон. | 01-12 | 100 |
| 24. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/35 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах | Арга хэмжээний тоо | - | 1 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/35 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд хууль зүйн чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний талаар баталсан хууль тогтоомж, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэр, дүрэм, журмыг дагаж мөрдөх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн гишүүд чиг үүргийн хүрээнд 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүдээс салбарын хууль тогтоомжийн мэдлэгийн түвшин тогтоохоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201, 352, 2023 оны 100 дугаар тогтоолын хүрээнд нийт 55 асуулга бүхий шалгалтын материал боловсруулж, шалгалтад ашиглагдах хууль тогтоомж, шалгалт авах зааварчилгааг албан хаагчдад хүргүүлж, нийт 37 албан хаагчаас хууль, тогтоомжийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авсан. | 01-12 | 100 |
| 25. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар "Цахим | Арга хэмжээний тоо | - | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар "Цахим аймаг" төслийн тоног төхөөрөмж (Дундговь) | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аймаг" төслийн тоног төхөөрөмж (Дундговь) худалдан авах, төсөл арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой эрхийг Төрийн цахим үйлчилгээний газарт шилжүүлсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах | | | | худалдан авах, төсөл арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой эрхийг Төрийн цахим үйлчилгээний газарт шилжүүлсэн.<br>Тус газар нь худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж "Би Си Ти" ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр УТ2406700149 дугаартай "Цахим аймаг төслийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ"-г байгуулсан. "Би Си Ти" ХХК нь гэрээнд заасан тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу нийлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тул гэрээний хугацааг 30 хоногоор сунгах хүсэлтийг 06 дугаар сарын 10-ны өдөр ирүүлснээр тус газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/61 дүгээр тушаалаар ТЦҮЗГ/20240302001 дугаартай "Цахим аймаг" төслийн тоног төхөөрөмж (Дундговь) тендерийн гэрээний хэрэгжилтийн явцад үүссэн нөхцөл байдалд дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгээс нийлүүлэгч талтай 3 удаагийн уулзалт зохион байгуулж, гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал үүссэн болохыг нотлох шаардлагыг хүргүүлснээр Худалдаа аж үйлдвэрийн танхимын "Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ" -г ирүүлж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмжийг төсвийн шууд захирагчид хүргүүлсэн. Тухайн компани нь 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр гэрээнд заасан тоног төхөөрөмжийг шалган хүлээн авч, 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдөр акт үйлдэж баталгаажуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 2024 оны 07 дугаар сарын 15-ны өдөр санхүүжилтэд шаардлагатай баримт бичгийг стандартын дагуу боловсруулж хүргүүлсэн бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр "Би Си Ти" ХХК-д холбогдох санхүүжилтийг олгосон. | | |
| 26. | ТЦҮЗГ/20240102003 дугаар тендерийн гүйцэтгэлийг хүлээн авах агентлагийн даргын А/66 | Ажлын тоо | - | 1 | ТЦҮЗГ-аас зохион байгуулсан ТЦҮЗГ/20240102003 дугаар тендерийн гүйцэтгэлийг хүлээн авах агентлагийн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хэрэгжилтийг хангах | | | | даргын А/66 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Сонгинохайрхан дүүргийн Өнөр цогцолбор, 143, 121, 151, 105 дугаар сургууль дээр ажиллаж, тендер нийлүүлэхэд ирүүлсэн бараа материалыг хүлээж авах ажлыг хийж гүйцэтгэн, тоног төхөөрөмж хүлээн авах ажлын комиссын ажлын явцын тэмдэглэлийг үйлдэж газрын даргад танилцуулсан. | | |
| 27. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/67 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах | Судалгааны тоо | - | 1 | Төрийн байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээ, үйлчилгээний чиглэлийг тодорхойлох, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны загварыг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/67 дугаар тушаалаар байгуулж, 18 аймаг, 33 агентлагаас ирүүлсэн судалгааг нэгтгэх, танилцуулах ажлыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнгээр 18 аймаг 7446, Засгийн газрын 34 агентлаг 755, нийт 8201 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна. Үүнээс: Төрийн үйлчилгээний системд нэвтэрсэн 774, цахим хэлбэрт шилжүүлсэн 3968, бусад системд нэвтэрсэн 3928, цахим хэлбэрт шилжээгүй 4233 үйлчилгээ байна. | 01-12 | 100 |
| 28. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр баталсан Нийслэлийн төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгт ажиллах албан хаагчдын хуваарийн дагуу ажиллах, газрын албан хаагчдыг ажиллах нөхцөл боломжоор хангах | Цэгийн тоо | - | 4 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр баталсан Нийслэлийн төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгт ажиллах албан хаагчдын хуваарийн дагуу “Иргэдэд мэдээлэл өгөх төв”-ийн 1 дүгээр давхарт байрлах ХУРДАН цэг, Төв шуудан дахь ХУРДАН цэг, Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо Тоосгоны үйлдвэрийн эцсийн буудалд байрлах ХУРДАН цэгт Чанар хяналтын мэргэжилтнүүд хуваарийн дагуу ажиллан, үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлж байгаа байдал, киоск машинаар хүн, хуулийн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | этгээд үйлчилгээ авч байгаа байдалтай танилцан, илтгэх хуудсыг холбогдох нэгжид цахимаар хүргүүлсэн. | | |
| 29. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд шинээр мэдээлэл хариуцагч байгууллагын 100 үйлчилгээг нэвтрүүлэх "Ухаалаг засаг 2" төслийн даалгаврыг боловсруулах | Төслийн даалгаврын тоо | - | 1 | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1, 4.1.3, 4.5.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 5.3.13, 5.3.21 дэх заалт, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1 дэх хэсэгт тусгагдсан төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, төрийн хүнд суртлыг бууруулах зорилт, хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих зорилт болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/53 дугаар тушаалаар батлагдсан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, аймаг, орон нутгийн цахим шилжилтэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-ыг үндэслэн Төрийн үйлчилгээний нэгдсэн системд шинээр мэдээлэл хариуцагч байгууллагын 100 үйлчилгээг нэвтрүүлэх "Ухаалаг засаг 2" төслийн даалгаврыг боловсруулсан. | 01-12 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | | | Гүйцэтгэлийн түвшин |
|---|---|---|---|

| | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Байгууллагаас болон бусад газраас зохион байгуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | 10 | 4 | 1. Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын танилцуулга 2024.01.11;<br>2. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газраас зохион байгуулсан “Цахим эринд хүний эрхэнд суурилсан хөгжлийг дэмжих нь” симпозиумд 2024.01.11-12<br>3. Shilen.gov.mn 2:0 сургалт 2024.03.14;<br>4. “Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага” сэдвээр Төрийн албаны зөвлөлийн цахим сургалт 2024.03.21;<br>5. Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт “Дижитал шилжилт, Виртуал орчинд ажиллах” цахим сургалт 2024.03.14;<br>1. ERP системийн цахим сургалт 2024.03.15;<br>2. Төрийн банкнаас зохион байгуулсан мэдээлэл 2024.03.18;<br>3. "Аж үйлдвэрийн хувьсгалууд ба сансар судлал" сэдвээр сургалт МУИС-ийн физикийн тэнхимийн дэд профессор Д.Эрдэнэбаатар 2024.04.05;<br>4. “Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв” УТҮГ, “Систем арт венчурс” ХХК-тай хамтран Жижиг, дунд үйлдвэрийн газраас хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг дахин загварчлах, оновчлох” зорилготой ажлын хэсгийн танилцуулга 2024.05.09<br>5. Авлигатай тэмцэх газраас “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” хүрээнд цахим сургалт 2024.05.14; | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 6. Танхимд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай /Анхдагч хуулийн төсөл/ хэлэлцүүлэг 2024.05.14;<br>7. Эрүүл мэндийн сургалт 2024.05.24;<br>8. Эрүүл мэндийн өдөрлөг, үзлэгийн арга хэмжээ 2024.06.18;<br>9. Захирамжлалын баримт бичгийн үндэслэл, хүний нөөцийн бодлого, баримт бичиг боловсруулах аргачлал сэдвээр Удирдлагын академи 2024.07.05;<br>10. Иог хийхийн ач тус сургалт;<br>11. "Шударга байдлын үнэлгээ"-ний судалгаа Авлигатай тэмцэх газар 2024.08.15;<br>12. Монгол Улсад иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэх нь сэдвээр танилцуулга Япон Улсын Мэйжи их сургууль, Засаглал судлалын тэнхимийн магистрын оюутан У.Энхжин 2024.08.16;<br>13. Эрүүл амьдралын нууц, зөв хооллолтын тухай мэдээлэл мэргэжилтэн Б.Улсболд 2024.08.16;<br>14. Бүгд найрамдах улс тунхаглаж, анхдугаар үндсэн хууль баталсан түүхт өдрийг тохиолдуулан мэдээлэл Захиргаа удирдлагын газрын архивын зааварлагч, арга зүйч Т.Эрдэнэхишиг;<br>15. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2024/0563 А3 гэрчилгээ;<br>16. АЙ ЭМ ЭС ЭЙ ХХК-аас зохион байгуулж буй чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2022 стандартуудыг нэвтрүүлэх сургалт;<br>17. Сургагч багш бэлтгэх сургалтад 2 мэргэжилтэн;<br>18. Судалгааны эрх зүйн анхан шатны сургалт;<br>19. Төрийн албаны чиглүүлэх сургалтад 2, дунд шатны сургалтад 1 албан хаагчийг хамруулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт 17 сургалтад хамрагдсан. | | |
| 2. | Удирдлагын академиас зохион байгуулагдах богино хугацааны сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | - | 2 | “Удирдах арга барил” 16 цагийн сургалтад 2024 оны 02 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд хамрагдсан.<br>Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь 40 цагийн цахим, танхим хосолсон сургалтад 2024 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд хамрагдсан. | 01-12 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ЧАНАР ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА /И.ХАЙРАТБЕК/ 2024.12.04